



### НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 1/29


Улаанбаатар хот

#### Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/122, А/400 дугаар захирамж, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын “Захирамжид өөрчлөлт оруулах тухай” 2021 оны А/400 дугаар захирамжийн дагуу газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалын 1 дэх хэсэгт Ахмад настан болон хүүхэд, залуучуудад зориулсан тоглоомын болон биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбайн засвар шинэчлэлт, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх (Хан-Уул дүүрэг 4 дүгээр хороо), Яармагийн гэр хорооллын иргэдийн эрүүл аюулгүй байдал, Иргэдийн оролцоо сэтгэл ханамжийн судалгаа (Хан-Уул дүүрэг 4, 5, 6, 7, 8 дугаар хороо), Зайсан орчимд орчны аюулгүй байдал, орон зайн судалгаа, төлөвлөлт (Хан-Уул дүүрэг 11 дүгээр хороо), Яармагийн иргэд, хүүхэд залуучуудын амны хөндийн өвчлөлийг бууруулах, анагаах шүдний кабинет байгуулах (Хан-Уул дүүрэг 7 дугаар хороо), Эрчим хүчний гудамжны засвар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо), Байрны завсар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг 11 дүгээр хороо) гэж тус тус өөрчлөлт оруулсугай.

ДАРГА



Б. МӨНХБАТ

315067000166